

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9 Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12 Шилэн дансны мэдээлэл	7
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
Менежментийн захидал	8
Аудит хийсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудитын хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	10
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	10
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.5 Аудит хийсэн 2019 оны зорилтот түвшин, гүйцэтгэл.....	12
Хавсралт	13
5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/798
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Монгол Ус ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Оршил

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Билэгсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Ус ТӨААТҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 5-наас 2020 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Монгол Ус ТӨААТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Э.Энхбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 1/69 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Ус ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь стратегийн үнэт баялаг бөгөөд хүн ам, хот суурины хөгжил, улс орны нийгэм эдийн засгийн бүх салбарын үндсэн хэрэглэгдэхүүн болох усны нөөцийг хамгаалах, чанарыг сайжруулах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, улмаар үндэсний аюулгүй байдал, улс

орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

Монгол Ус ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усны нөөцийг зөв зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх;
- Газрын доорх усны нөөцийг тогтоох, эрэл хайгуул судалгаа хийх;
- Усны чанар стандартад усны шинжилгээ хийх;
- Хүн амын унд ахуй, үйлдвэрийн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох;
- Хяналт мониторингийн иж бүрэн тогтолцоог нэвтрүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн газрын доорх усны ордуудыг ашиглуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Монгол Ус ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцсэн байна.

Монгол Ус ТӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив Би Ай ХХК-ийн Даймонд программ хангамж ашигладаг байна.

Монгол Ус ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Ус ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 631.5 сая төгрөгийн 2 хувиар тооцож, 12.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлон, баталгаажуулсныг аудитын гүйцэтгэх үе шатанд өөрчлөөгүй болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84.7 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	842.5	401.3	-441.2
АВЛАГА	17.1	23.0	5.9
УРЬДЧИЛГАА	1.9	8.1	6.2
БАРАА МАТЕРИАЛ	8.4	345.6	337.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,442.2	1,418.5	-23.7
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	-	30.9	30.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,312.1	2,227.4	-84.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	617.9	361.0	-256.9
Эздийн өмч	1,694.2	1,866.4	172.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,312.1	2,227.4	-84.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд хэрэгжүүлсэн төслийн ажлуудын гэрээний төлбөр болон үйл ажиллагааны зардал өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019-2020 онд хийж гүйцэтгэх Саусгоби сэндс ХХК-ийн захиалгаар Овоот толгойн нүүрсний уурхайн гидрогеологийн нэмэлт судалгааны ажлын гүйцэтгэл 332.4 сая төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь ТӨБЗГ-ын 2018 оны 576 дугаар тогтоолын дагуу 82.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тус газрын 2019 оны А-5/1004 тоот албан бичиг, 2019 оны 201 дүгээр тогтоолоор акталсан нийт 22.5 сая төгрөгийн хөрөнгө хасагдсанаас шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 121.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө өссөн нь газрын эзэмших эрхийн гэрчилгээтэй 955 м.кв газрыг 30.9 сая төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 602.1 сая төгрөгийн Грийн энерги проспекити ХХК-ийн захиалгат гэрээт ажил бүрэн хийгдэж, тайлант онд борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрсөн, 2019-2020 онд хэрэгжих Саусгоби сэндс ХХК-ийн 351.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг өр төлбөрөөр бүртгэсэн байна.

2.9 ЗОРИЛТОТ ТҮВШИН, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 588 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 884.4 сая төгрөгөөр, зардлыг 783.5 сая төгрөгөөр, 2 дугаар хавсралтаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 121.8 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 1,392.2 сая төгрөг, хүүгийн болон бусад орлогоос 37.4 сая төгрөг нийт 1,429.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж зорилтот түвшний орлогыг төлөвлөгөөг 61.7 хувиар буюу 545.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Нийт зардалд 783.5 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 1,272.6 сая төгрөг буюу 489.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Грийн энерги проспекити ХХК-ийн захиалгаар гүйцэтгэсэн судалгааны ажлын өртгөөс шалтгаалжээ.

2.10 АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 41.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 30.9 сая төгрөгийн алдааг залруулж, 10.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

1. Тус байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 955 м.кв газрыг 30.9 сая төгрөгөөр үнэлж биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмчийн өөрчлөлтийн тайланд 30.9 сая төгрөгийн залруулга хийсэн.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Эвиденсе аудит ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах гэсэн зөвлөмж өгч тус аудитын компани 4.9 сая төгрөгийн гэрээ байгуулж бодлогын баримт бичиг боловсруулж өгсөн байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Монгол Ус ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт:

Өмнөх онд шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон 173.8 сая төгрөгийн найдваргүй авлагыг зардлаар хүлээн зөвшөөрснөөр 107.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд дээрх алдагдлыг хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэж баталгаажуулаагүйгээс 10.7 сая төгрөгийн алдагдлыг тайлант оны татвар ногдуулах орлогын дүнгээс хасаж тооцох боломжгүй болсон байна.

1.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам зааврын мөрдөж ажиллаагүй байх.

1.1.3 Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн жил бүр албан татвар ногдуулах орлогын нийт дүнгийн 50 хувиар хязгаарлан хасаж тооцно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	842,483,104.08	401,282,834.35
1.1.2	Дансны авлага	6,314,900.00	4,510,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	10,818,439.24	18,569,144.08
1.1.6	Бараа материал	8,421,284.64	345,606,656.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,902,017.35	8,092,238.49
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	869,939,745.31	778,060,873.29
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,442,185,074.13	1,418,467,409.58
1.2.2	Биет бус хөрөнгө	0.00	30,922,900.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,442,185,074.13	1,449,390,309.58
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,312,124,819.44	2,227,451,182.87
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	8,518,092.51	6,000,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	6,861,578.72	0.00
2.1.1.3	Татварын өр	496,000.00	3,539,555.56
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	602,070,378.00	351,505,000.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	617,946,049.23	361,044,555.56
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	617,946,049.23	361,044,555.56
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	1,674,923,107.29	1,705,846,007.29
2.3.9	Хуримтлагдсан ашиг	19,255,662.92	160,560,620.02
2.3.20	Эздийн өмчийн дүн	1,694,178,770.21	1,866,406,627.31
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2,312,124,819.44	2,227,451,182.87

4.2 Аудитын хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	694,970,942.08	1,392,196,860.65
2	Борлуулалтын өртөг	253,896,109.94	794,867,424.50
3	Нийт ашиг (алдагдал)	441,074,832.14	597,329,436.15
4	Хүүгийн орлого	5,423,135.49	22,880,278.11
5	Бусад орлого	250,000.00	11,116,340.09
7	Ерөнхий ба удирдлагын зардал	380,237,089.73	474,959,204.66
9	Бусад зардал	173,804,108.30	2,815,900.00
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,317.22	145,424.72
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-130,810.00	3,309,133.47
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-107,420,723.18	157,005,507.88
13	Орлогын татварын зардал		15,700,550.78
14	Татварын дараах ашиг (алдагдал)	-107,420,723.18	141,304,957.10
15	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-107,420,723.18	141,304,957.10
17	Орлогын нийт дүн	-107,420,723.18	141,304,957.10
18	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,674,923,107.29	129,075,576.10	1,803,998,683.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
3	Залруулсан үлдэгдэл	1,674,923,107.29	129,075,576.10	1,803,998,683.39
4	Бусад дэлгэрэнгүй орлого			
5	Өмчид гаргасан өөрчлөлт			
6	Зарласан ногдол ашиг			
7	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	0.00	-107,420,723.18	-107,420,723.18
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,674,923,107.29	19,255,662.92	1,694,178,770.21
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
11	Залруулсан үлдэгдэл	1,674,923,107.29	19,255,662.92	1,694,178,770.21
12	Бусад дэлгэрэнгүй орлого			
13	Өмчид гаргасан өөрчлөлт			
14	Зарласан ногдол ашиг			
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	141,304,957.10	141,304,957.10
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	30,922,900.00	0.00	30,922,900.00
17	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,705,846,007.29	160,560,620.02	1,866,406,627.31

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,470,556,812.82	1,115,342,328.06
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,470,556,812.82	1,111,268,137.28
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	4,074,190.78
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	692,221,247.02	1,458,074,210.61
1.2.1	Ажиллагчдад төлсөн	337,387,841.44	385,682,440.28
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	76,990,210.21	90,671,194.93
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	31,322,741.52	661,754,830.66
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	564,100.00	8,612,900.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,980,209.11	23,652,846.28
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	41,869,312.51	92,396,884.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	213,840.00	395,608.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	182,892,992.23	194,907,505.83
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	778,335,565.80	-342,731,882.55
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,423,135.49	22,880,278.11
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,423,135.49	22,880,278.11
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	53,303,658.27	121,494,090.01
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	53,303,658.27	121,494,090.01
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-47,880,522.78	-98,613,811.90
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,400.21	145,674.12
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	3,400.21	145,674.12
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,399,190.00	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	2,399,190.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		249.40
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,395,789.79	145,424.72
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	728,059,253.33	-441,200,269.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	114,423,850.85	842,483,104.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	842,483,104.08	401,282,834.35

4.5 Аудит хийсэн 2019 оны зорилтот түвшин, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	884,400.0	1,429,648.0	-545,248.0	161.7
	Үүнээс цэвэр борлуулалт	884,400.0	1,392,196.9	-507,796.9	157.4
2	Нийт зардал	783,458.1	1,272,642.5	-489,184.4	162.4
	Удирдлага/бор-ын зардал	480,673.4	474,959.2	5,714.2	98.8
3	Татварын өмнөх ашиг/алдагдал	100,941.9	157,005.5	-56,063.6	155.5
	Орлогын татварын зардал	10,094.2	15,700.6	-5,606.4	155.5
4	Цэвэр ашиг /-/	90,847.7	141,305.0	-50,457.2	155.5
5	Төсвийн төлбөрт	140,756.5	208,333.4	-67,576.9	148.0
	а/ Аж ахуйн нэгжийн орлогын албан /тат	10,094.2	15,700.6	-5,606.4	155.5
	б/ НДШ, ЭМД	95,832.0	90,671.2	5,160.8	94.6
	в/ ХХОАТ	30,078.1	32,768.7	-2,690.6	108.9
	д/ Ногдол ашиг	9,084.8		9,084.8	-
	е/ Бусад	4,218.2	69,193.0	-64,974.8	1,640.3
6	Ажиллагсдын тоо	38	33	5	86.8
7	Нийт цалингийн сан	399,300.0	382,841.1	16,458.9	95.9
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.89	0.89	-	100.0
9	Нийт авлага		23,079.1	-23,079.1	
10	Нийт өглөг		361,044.6	-361,044.6	
11	Хөрөнгө оруулалт	121,755.6	121,494.1	261.5	99.8

5.1 АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Огноо: 2020/03/13	Аудитын нэр:	<i>Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудит</i>	Аудитын код: САГ-2020/68/ СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Ус ТӨААТҮГ		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Өмнөх онд шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон 173.8 сая төгрөгийн найдваргүй авлагыг зардлаар хүлээн зөвшөөрснөөр 107.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд дээрх алдагдлыг хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэж баталгаажуулаагүйгээс 10.7 сая төгрөгийн алдагдлыг тайлант оны татвар ногдуулах орлогын дүнгээс хасаж тооцох боломжгүй болсон байна.	10.7	Зөвлөмж өгөх	Санхүү, хяналтын хэлтсийн дарга	М.Энхтүвшин
	Нийт	10.7			

